

**СҮЛЖЭЭНИЙ ДЭД БҮТЦИЙН ХЭЛТСИЙН ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ
Э.ОЮУН-ЭРДЭНИЙН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
ЗОРИЛТ 1. "ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН БОДЛОГО, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1.1	Арга хэмжээ 1.1. "Телевизийн олон сувгийн нэвтрүүлгийг орон даяар дамжуулах үйлчилгээний хяналтын журам"-ын хэрэгжилтийг хангуулна.	Хяналт, шалгалтын тайлангийн тоо	Улирал бүр	-	Биелэлт: Биелэлт: "Сансрын холбооны кей юү (КУ) зурвасын технологиор телевизийн олон сувгийг орон даяар дамжуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ"-ний хүрээнд тус яамны сайдын 2022 оны 02 сарын 28-ны өдрийн А/10 дугаар тушаалаар батлагдсан "Телевизийн олон сувгийн нэвтрүүлгийг орон даяар дамжуулах үйлчилгээний хяналтын журам"-ын хоёрдугаар хэсгийн дагуу хяналтын комисс нь Нэгдүгээр улирлын хэмжилт, шалгалтыг 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдөр хийж тайланг боловсруулан баталгаажуулж ХОСХэлтэсд хүргүүлсэн. Хоёрдугаар улирлын хэмжилт, шалгалтыг журамд заасны дагуу 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдөр хийж тайланг боловсруулан баталгаажуулж ХОСХэлтэсд хүргүүлсэн.	2025.01.15 – 2025.06.15	100%

1.2	Арга хэмжээ 1.2. Өргөн нэвтрүүлгийн сүлжээгээр дамжуулах гамшгийн болон онцгой байдлын талаар урьдчилан сэргийлэх үеийн мэдээ, мэдээлэл дамжуулах журмын хэрэгжилтийг хангах;	Холболт хийсэн байгууллагын тоо	1	4	Биелэлт: Тайлант хугацаа болоогүй. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 дахь заалт "Өргөн нэвтрүүлгийн сүлжээгээр дамжуулах гамшгийн болон онцгой байдлын талаар урьдчилан сэргийлэх үеийн мэдээ, мэдээлэл дамжуулах журам"-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Онцгой байдлын ерөнхий газрын Шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвийн зарлан мэдээллийн системд Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийг холбох ажлыг эрчимжүүлэхээр ЦХИХХЯ, ОБЕГ, Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийг холбоотой 2025 оны 04 дүгээр сарын 23, 05 дугаар сарын 06-ны өдөр хамтын ажиллагааны 3 талт санамж бичиг байгуулах талаар урьдчилсан уулзалтыг тус тус зохион байгуулж, 02/1376 дугаартай албан бичгийг ОБЕГ-т хүргүүлсэн.	2025.01.15 – 2025.12.15	70%
1.3	Арга хэмжээ 1.3. Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн 2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж батлуулах, Хяналтын зөвлөлийн хурлыг зохион байгуулах;	Батлагдсан төлөвлөгөө, Хурлын протокол 4	Батлагдсан төлөвлөгөө 1, Улирал бүр хурал зохион байгуулах		Биелэлт: Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн хэрэгжилтийн хүрээнд ЦХИХХ-ны Сайдын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/77 дугаартай тушаалаар Хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлуулж, Хяналтын зөвлөлийн 2025 оны нэгдүгээр улирлын хурлыг 01 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулж хурлын протокол бичсэн. Тус хурлаар Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн 2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөнд санал авч, Хяналтын зөвлөлийн даргыг санал хураалтаар сонгосон. "Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөө" болон "Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө"-г Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн А/04 дугаартай тушаалаар батлуулсан. Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий үнэлгээний хорооны тушаалыг төслийг боловсруулж	2025.01.15 – 2025.12.15	100%

					2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн Төрийн нарийн бичгийн даргын А/35 дугаартай тушаалаар батлуулсан. Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/42 дугаартай тушаалаар дахин батлуулсан. Хяналтын зөвлөлийн 2025 оны хоёрдугаар улирлын хурлыг 06 дугаар сарын 13-ны өдөр хийж хурлын тэмдэглэл бичсэн.		
ЗОРИЛТ 2. “ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭХ, БОДЛОГО, МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨМЖӨӨР ХАНГАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
2.1	Арга хэмжээ 2.1. Телевизийн сувгийн үзэлтийн тоог олон нийтэд нээлттэй болгох судалгаа хийх;	Судалгааны тоо	-	-	Биелэлт: Тайлант хугацаа болоогүй. Хятад, Англи, Израйл, Америкийн нэгдсэн улсуудын телевизийн сувгийн үзэлтийн тоог олон нийтэд нээлттэй болгох судалгааг хийж танилцуулга боловсруулсан.	2025.06.15- 2025.12.15	50%
2.2	Арга хэмжээ 2.2. Өргөн нэвтрүүлгийн орчинд хүүхэд хамгааллыг талаарх мэдлэг ойлголтыг олон нийтэд таниулах арга хэмжээ зохион байгуулах;	Арга хэмжээний тоо	-	1	Биелэлт: Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Girls in ICT” өдөрт зориулсан арга хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр НҮБ-ын Хүүхдийн Сан, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, “И-Монгол академи” УТҮГ, Харилцаа холбооны зохицуулах хороо, Монголын хүүхдийн зөвлөлтэй хамтран зохион байгуулсан бөгөөд ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 150 гаруй охид оролцсон юм. Тус арга хэмжээгээр Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25 дугаар зүйл “Хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчин дахь хүүхэд хамгаалал”-ын мэдлэг мэдээлэлийг таниулах, хүүхдийн насны онцлогт тохирсон контент, цахим орчинд өөрийн аюулгүй байдлаа хэрхэн хамгаалах, цахим орчинд шударга байдлыг төлөвшүүлэх мэдээллийг хүргэх нөлөөллийн арга хэмжээ юм. Мөн тус арга хэмжээнд охидод мэдлэг олгох багийн тэмцээн зохион байгуулж шүүгчээр ажилласан.	2025.06.15- 2025.12.15	100%
ЗОРИЛТ 3. “ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							

3.1	Арга хэмжээ 3.1.Өргөн нэвтрүүлгийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх сургалт семинар зохион байгуулах;	Салбарын байгууллагатай хамтран ажилласан байна. Сургалт зохион байгуулсан байна.	-	1	Биелэлт: Тайлант хугацаа болоогүй. ICT EXPO 2025 Инженер техникийн ажилтнуудын ур чадварын сургалт, тэмцээнийг зохион байгуулахаар Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн холбоотой 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр уулзалт хийж хамтран зохион байгуулахаар болсон.	2025.06.15-2025.12.15	30%
ЗОРИЛТ 4. "ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ"							
1	Арга хэмжээ 4.1. Хууль тогтоомж болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн хүрээнд ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох журмын дагуу боловсруулж батлуулах, тайлагнах;	ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тоо, ТЖАХ-ийн гүйцэтгэлийн биелэлтийн тоо,	ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тоо - 1 ТЖАХ-ийн гүйцэтгэлийн биелэлтийн тоо - 1	ТЖАХ-ийн гүйцэтгэлийн биелэлтийн тоо - 1	Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, нэгжийн удирдлагаар батлуулж, батлагдсан загварын дагуу 2025 оны эхний хагас жилийн биелэлтийг гаргасан.	2025.01.15 – 2025.12.15	100%
2	Арга хэмжээ 4.2. Тушаал шийдвэр цаг үеийн болон бусад асуудлаар удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх;	Үүрэг даалгаврыг хугацаанд нь гүйцэтгэсэн эсэх	Үүрэг даалгаврыг хугацаанд нь гүйцэтгэж, эргэн тайлагнасан байна.	Үүрэг даалгаврыг хугацаанд нь гүйцэтгэж, эргэн тайлагнасан байна.	Чиг үүргийн дагуу бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гарган, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэн ажилласан.	2025.01.15 – 2025.12.15	100%

3	Арга хэмжээ 4.3. Чиг үүргийн дагуу бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гарган, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх	Холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлсэн эсэх	-	-	2025 оны эхний хагас жилийн байдлаар 48 албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэн хаасан.	2025.01.15 – 2025.12.15	100%
4	Арга хэмжээ 4.4. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон холбогдох журам, стандартад нийцүүлэн баримт бичгийн төсөл төлөвлөх, архивын нэгж бүрдүүлэх	Хууль болон холбогдох журамд нийцүүлэн баримт бичгийн төсөл төлөвлөж, архивын нэгж үүсгэсэн эсэх	-	Баримт бичгийг хугацаанд нь бүрэн архивласан байна.	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон холбогдох журам, стандартад нийцүүлэн баримт бичгийн төсөл төлөвлөн ажиллаж байна.	2025.01.15 – 2025.12.15	100%
5	Арга хэмжээ 4.5. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, холбогдох журамд заасны дагуу цохогдсон өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэх	Өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэсэн тоо	-	Тухай бүр	Тайлант хугацаанд 4 иргэнээс гомдол ирснийг хугацаанд нь шийдвэрлэсэн.	2025.01.15 – 2025.12.15	100%
6	Арга хэмжээ 4.6. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг мөрдөх хэрэгжилтийг хангах	Тухай бүр	-	Тухай бүр	ХАСХОМ-ийг 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор шинэчлэн гаргасан байна. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг 2024 оны 2 дугаар сарын 15-ны өдөр шинэчлэн мэдүүлсэн.	2025.01.15 – 2025.12.15	100%

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
-----	----------------------------------	---------------------	-------	-----------------	-------------------------	--------------------------------	---------------------

			түвш ин				
1.	Үүрэг даалгавар 1. Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журмыг батлуулах;	Журам батлуулах	-	Журмын төслийг эцэслэнбат луулсан байна.	Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25.11-д "Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журмыг цахим хөгжил, харилцаа холбооны, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална." гэж заасны дагуу ЦХИХХЯам,ГБХНХЯам, ХХЗХороотой журмын төслийг хамтран боловсруулж 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд нарын "Журам батлах тухай" А/53/А/95/А/76 дугаар тушаалаар батлуулж, Захиргааны ерөнхий хуулийн дагуу захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр 7204 дугаараар бүртгүүлсэн.	2025.01.15 – 2025.04.16	100%
2.	Үүрэг даалгавар 2. Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний ажлын даалгаварыг боловсруулж Төрийн нарийн бичгийн даргаар батлуулах.	Ажлын даалгавар батлуулах	-	Ажлын даалгавар батлуулсан байна. 6	Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний ажлын даалгаваруудыг боловсруулан 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. Үүнд: 1. Хүүхдэд зориулсан нэвтрүүлэг бэлтгэн хүргэх үйлчилгээний ажлын даалгавар 2. Үндэсний түүх, соёл, уламлалыг олон нийтэд таниулан сурталчлах нэвтрүүлэг бэлтгэн хүргэх үйлчилгээний ажлын даалгавар 3. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ хүрээгүй алслагдсан, сүлжээ хүрээгүй газарт сүлжээний хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын даалгавар 4. Сансар, хиймэл дагуулын талаарх танин мэдэхүйн мэдлэг мэдээллийг олон нийтэд	2025.03.28	100%

					таниулан сурталчлах нэвтрүүлэг бэлтгэн хүргэх үйлчилгээний ажлын даалгавар 5. Орон нутгийн бүтээл үйлдвэрлэл, орон нутгийн онцлогийг харуулсан түүх, соёл, уламжлал, хүүхэд, танин мэдэхүйн нэвтрүүлэг бэлтгэн хүргэх үйлчилгээний ажлын даалгавар 6. Танин мэдэхүйн нэвтрүүлэг бэлтгэн хүргэх үйлчилгээний ажлын даалгавар		
3.	Үүрэг даалгавар 3. Харилцаа холбооны цамхгийн металл хийцийн ядралын зэрэг тогтоох, үзлэг шалгалт хийх ажлыг зохион байгуулах" ажлын даалгаврыг батлуулах	Ажлын даалгавар батлуулах	-	Ажлын даалгавар батлуулсан байна.	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 тушаалаар батлагдсан 2025 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний ЦХИХХЯ/20250201022 дугаартай "Харилцаа холбооны цамхгийн металл хийцийн ядралын зэрэг тогтоох, үзлэг шалгалт хийх ажлыг зохион байгуулах" ажлын даалгаврыг боловсруулж батлуулсан.	2024.03.28	100%
4.	Үүрэг даалгавар 4. Тэрбум мод үндэсний хөдөлгөөнд оролцож мод тарих;	Мод тарих	-	Мод тарьсан байна.	Тэрбум мод үндэсний хөдөлгөөнд нэгдэж 2025 оны 05 дугаар сарын 10-ны өдөр Зэвсэнт хүчний мод үржүүлгийн талбайд мод тарьсан.	2024.05.10	100%

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт


Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн; дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7

1.	Арга хэмжээ 1. Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх АЗ эрх авах;	Сертификат авсан эсэх (тийм 1, үгүй 0)	-	-	Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх сургалтанд хамрагдсан.	2025.01.15 – 2025.12.15	20%
2.	Арга хэмжээ 2. Эрхэлсэн ажлын чиглэлээр зохион байгуулагдах хурал, сургалт, семинарт хамрагдах;	Холбогдох хурал, сургалт, семинарт тухай бүрд оролцсон эсэх (тийм 1, үгүй 0)			1. ТА3-аас зохион байгуулж байгаа 7:4:10 –ийн зохион байгуулагдсан сургалтад тухай бүр хамрагдсан. 2. Харилцаа холбооны зохицуулах хорооны Хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалахад чиглэсэн Орон тооны бус зөвлөлийн 2025 оны 1 дүгээр улирлын хуралд оролцож, Зөрчил илэрсэн телевизүүдийн асуудлыг хэлэлцэн мэдэгдэл хүргүүлэхээр шийдвэрлэсэн. 3. Харилцаа холбооны зохицуулах хорооноос өргөн нэвтрүүлгийн салбарын хөгжлийн чиг хандлага, технологийн дэвшил, бүтээл үйлдвэрлэл, олон улсын хамтын ажиллагаа зэрэг асуудлыг хэлэлцэх "Өргөн нэвтрүүлгийн хөгжил – 2025" форумыг 2025 оны 05 дугаар сарын 09-ны өдөр зохион байгуулсан бөгөөд тус яамыг төлөөлж чиг үүргийн дагуу оролцсон.	2025.01.15 – 2025.12.15	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН БОДЛОГО
ЗОХИЦУУЛАЛТЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН
ШИНЖЭЭЧ

(Албан тушаал)

 / Э.Оюун-Эрдэнэ /
(Нэр, гарын үсэг)

.....
(Огноо)